

“Овог” хэмээх нэр томъёоны орчин үеийн ойлголтыг судалсан урьдчилсан дүнгээс

Г.Цэрэнханд¹ Л.Билэгт²

¹Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Угсаатан судлалын тэнхим

²Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Угсаатан судлалын тэнхим

“Овог” гэдэг нэр томъёоны орчин үеийн ойлголт дундат үеийнхээс ихээхэн ялгаатай боловч уг гарал нь шууд холбоотой бөгөөд бүтэц зүйн хувьд тэр хэвээрээ үлдсэн үг юм. Дундад үеийн монгол хэлэнд ба нийгмийн харьцааны хэрэглээнд байсан “овог” хэмээх ай XX зууны турш маргаантай асуудлын нэг байв. Өнгөрсөн зууны эхний хагаст Б.Я.Владимирцов (1934 он), В.Котвич (1949 он) нарын үндэслэсэн хоёр үзэл баримтлал зэрэгцэн оршсоор байна (тоймыг Билэгт, 1999,х.94-97). Ер нь XI–XII зууны Төв Азийн нүүдэлчдийн дотор байсан “овог” гэдгийг бүх монгол судлаачид санал нэгтгэйгээр нийгмийн зохион байгуулалтын нэгж гэж үздэг. Маргааны гол зангилаа нь түүний бүрэлдэхүүн, функцийн талаар байгаа юм. Сүүлийн үед монгол судлаачдын олонх хэсэг нь XI-XII зууны “овог” зөвхөн нэг төрлийн хүмүүсээс бүрддэггүй гэсэн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч байна. Монголын нутагт XI-XII зууны үед байсан нүүдэлчдийн “овог”-ийн бүрэлдэхүүнд нас, хүйс, угсаа гаралын хувьд янз бүрийн хүмүүс байсныг “Монголын Нууц Товчоо”, Рашид-ад-дины “Судрын чуулган” хоёр маш тодорхой харуулж өгдөг. Энгийн логикоор бодсон ч нэг овогт зөвхөн төрсөн ах дүү нар байсан бол зарим хэсгийгээ bogol, saraču, harad гэж нэрлээд баймааргүй. Овгийн нэр нь тухайн үеийн нүүдэлчин малчдын нийгмийн бүтцийн нэгжийн нэр бөгөөд энэ нь этноним биш, ураг төрлийн холбооны нэр биш, “фамилия, surname” бол бүр ч биш, үүсэл, хэвшил нь зөвхөн хүний нэртэй холбоотой биш, харин хувь хүний нэрэнд тодотгол байдлаар хэрэглэгдэж (Билэгт, 2000, с.144-170) байсан нийгмийн харьцааны нэг ай юм.

Бидний үзэж байгаагаар Чингис хаан нэгдсэн төр улс байгуулахдаа Төв Азийн нүүдэлчдийн дотор 400 орчим жил амь бөхтэй оршин тогтнож байсан “овог” хэмээх нийгмийн нэгжийг бүтэц, функцийн хувьд бодлогоор устгаж, засаг захиргааны “мянгат”-ын зохион байгуулалтыг хийсэн байна. Ингэснээр “овог” гэдэг ойлголт XIII зууны өмнөх байдлаар нийт нүүдэлчдийн дотор байхаа больж, “мянган, түмэн, гар” гэдэг нэр түгээмэл хэрэглэгдэх болжээ. “Мянган” хэмээх нэр томъёо 1400 оноос “отог” гэдгээр солигдов (Нацагдорж, 1970, х.5-11). “Овог” гэдэг нийгмийн бүтэц XIII зуунаас хойш өнгөрсөн үеийн түүхийн ойлголт болж, Алтан ургийнхны угийн бичиг, ургийн түүхэнд чухам энэ утгаар бичигдэж байсныг “гэрийн үеийн түүхүүд” харуулдаг. Бүх угсаатай, зэрэгтэй тайж нар <<боржигин овогт, хияд яст>> гэж манжийн үеийн албан бичигт тэмдэглүүлж байв. Гэхдээ үүнийг нэг ч сурвалж судлаач <<боржигин>> хэмээх овог оршин тогтнож байсны баримт, үндэс гэж махчлан ойлгохгүй нь мэдээж. Бодончарын, Есүгэй баатарын үеийн “боржигин” гэдэг овог аль эрт байхаа больсон нь тодорхой бөгөөд хожуу дундад үеийн монголын түүхийн сурвалжуудад мөн л өнгөрсөн үеийн түүхийн ай байдлаар овгийн тухай бичиж байжээ. Хүн амын дийлэнх олонх болох “boγol, saraču, haran”, хожим “хамжлага, ард” гэж нэрлэгдсэн хүмүүсийн “овгийн” талаар тухайн үеийн түүхийн ном, зохиолуудаас гэрчилсэн мэдээгүй байна. Их Монгол улс байгуулагдсанаас хойшхи улс төр, нийгмийн бүх орчин, нөхцөл нь, жирийн малчин ардын дунд урьдын «овог» гэдэг ай хэрэглээнээс гарах, мартагдах байдалд хүргэжээ.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хүн амын “овгийг сэргээх” үйл ажиллагаа нилээд эрчимтэй явагдаж, багагүй хөрөнгө зардал гарган явуулын шинжилгээ хийж, “овгийн лавлахыг” аймаг, сум тус бүрээр хэвлэн гаргав(Очир, Сэржээ, 1998, товх.). Одоогийн байдлаар тэрээхэн төслийн хувьд

“овог сэргээх” ажил үндсэндээ дуусаж, олон нийтийн хэрэглээнд “лавлах, зөвлөмж” байдлаар оржээ. Энэ ажлыг монголын хүн амын нөхөн үржилтийн аюулгүй байдал, чухамдаа “цус ойртолт боллоо” гэдэг шинжлэх ухааны судалгааны ор үндэслэлгүй шуугианыг үндэслэн, яаруу түргэн төрийн яамаар батлуулж, хэрэг дээрээ тодорхой онол, арга зүйд үндэслэсэн судалгааг урьдчилан хийлгүй эхэлжээ. Тухайлбал, 1918 оны хүн амын тооллогод “овог” гэж бичиж байсан зүйлийг «фамилия, surname» байдлаар хэрэглэхэд тохирох эсэх талаар нарийвчилсан судалгаа хийгээгүй байна.

Овгийн лавлахууд хэвлэгдэн гарснаас хойш мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, улмаар Монгол Улсын иргэн гэдгийг гэрчлэх баримт шинээр олгохдоо “овог” гэдэг зүйлийг албан журмаар бичих болов. Иргэний үнэмлэх олгох явцад хүн амын дотор “овгоо тогтоох” хөдөлгөөн эхэлсэн билээ. Удалгүй “сэргээж” бичигдсэн овгууд нийгмийн харьцаанд хэрэглэгдэх ач холбогдлоор муухан, хүн амын зарим хэсгийн хувьд ямар ч ач холбогдолгүй болохыг амьдрал харуулав. Жишээлбэл, газар, гол усны, засаг захиргааны, хошуу ноёны хоч, нэрсээр овоглосон олон тооны хүмүүс нэгэн “овгийн” хүмүүс болж, хэдийгээр төрлийн холбоогүй боловч холбоотой мэт үзэгдэх болжээ.

Иймээс бид ХХ зууны Монголын нийгмийн харьцаанд ба оюун санаанд “овог” гэдэг ойлголт ямар байсан, түүний гүйцэтгэж байсан үүрэг, хувьслыг угсаатан судлалын арга зүйн дагуу шинжлэх шаардлагатай гэж үзэв. Толилуулан буй өгүүллийн материалыг Хэнтий аймгийн Баян-Овоо, Батноров, Норовлин сумын нутагт, 2002 оны 7-р сарын 27-ноос 8-р сарын 16-нд хээрийн шинжилгээний ажлаар явж цуглуулав. Асуулгыг явуулахдаа мэдээлэгчдийн бага, идэр, залуу насны үед хүрээлэн байсан орчны талаархи дурсамжыг сонин хэвлэл, сэтгүүл, ном, радио, телевизээр авсан мэдээнээс ялган тусгаарлах арга зүйн бүх үйлдлийг хийлээ. Асуулгын эхэнд мэдээлэгчийн бага, идэр насны үеийн орчны тухай сануулах чиглэлээр яриаг (дөрвөн улиралд нутаглаж байсан газар орон, ус, ургамалын байдал, хариулж байсан малын төрөл зүйл, гэр сууц, өвөг, эмэг, эх, эцэг, авга, нагац ах, дүү нар, ахуйн талаар ба тэдний хийж, ярьж байсан зүйлсийн аль нэгнээс эхлэн аажмаар хандуулан асууж, санамжын орчныг бүрдүүлж) өрнүүлэв. Иргэний үнэмлэхэнд бичүүлсэн “овог”, иргэний паспортонд бичүүлсэн “овгийн” талаар сурвалжлагын төгсгөлийн хэсэгт ярилцаж, ярианы энэ хэсгийг түүнээс өмнөх үеийн (1910-1940-өөд оны) нийгэм, гол нь ахуйн харьцаанд ямар байдалтай хэрэглэгдэж байснаас тусгаарлахыг арга зүйн дагуу оролдсон. Түүхийн ном зохиол судлан уншдаг, уншсан зүйлээ яриад байсан зарим настангуудад, сурвалжлагын эхэн, дунд хэсэгт зориуд анхааруулан, зөвхөн бага, идэр насны ахуйн харьцааг санаж, боловсрол, хожим уншсан зүйлээс ялгуулж байв. Эцэст нь «овгийн лавлах» - д жагсаасан нэрсийг дурьдаж асуув. Энэхүү судалгаанд хамрагдсан мэдээлэгчидийг дурьдвал:

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын:

-- Жамсрангийн Өвгөнхүү, эр, 1929 онд Баян-Овоо сумын нутагт төрсөн, морь жилтэй.

--Тогоочийн Чойжил, эр, 1933 онд Баян-Овоо сумын нутагт төрсөн, тахиа жилтэй.

-- Түмэннастын Өлзийбаяр, эр, 1940 онд Баян-Овоо сумыг нутагт төрсөн, могой жилтэй.

Хэнтий аймгийн Батноров сумын:

-- Навааншаравын Намжил, эр, 1931 онд Батноров сумын нутагт төрсөн, мич жилтэй.

-- Навааншаравын Санжмятав, эр, 1938 онд Батноров сумын нутагт төрсөн, бар жилтэй.

-- Зэндмэнийн Аюурзана, эр, 1921 онд Батноров сумын нутагт төрсөн, могой жилтэй.

-- Бадамын Чойжил, эр, 1918 онд Батноров сумын нутагт төрсөн, хонь жилтэй.

-- Сэр-Одын Лувсаннамсрай, эр, 1921 онд Батноров сумын нутагт төрсөн, тахиа жилтэй.

-- Гомбожамцын Лувсанжамц, эр, 1920 онд Батноров сумын нутагт төрсөн, нохой жилтэй.

-- Намсрайн Гэндэн, эр, 1928 онд Батноров сумын нутагт төрсөн, могой жилтэй.

Хэнтий аймгийн Норовлин сумын :

-- Зундуйн Жамбаа, 1923 онд Норовлин сумын нутагт төрсөн, хулгана жилтэй.

--Шагдарын Дэмчиг, 1932 онд Дорнод аймгийн Түмэндэлгэр сумын нутагт төрсөн.

Хэнтий аймгийн гурван сумын мэдээлэгчдээс тус бүр нэгийн хариулсан байдлыг хэв шинжит жишээ болгон авч үзье. Баян-Овоо сумын уугуул, 73 настай Жамсрангийн Өвгөнхүү гуайн ярьснаар: "Би цэрэгт явахаас өмнө, 17-18 настай байхад "овог" гэж ярьдаггүй байсан, "ард халх" гээд л явдаг байсан, одоо сүүлийн үед л "овог" гэж ярьдаг болж.

-- Баатад ⇒ гэж нэр чих дэлсээгүй, огт сонсоогүй

-- Махилаг ⇒ гэдэг нэр огт сонсоогүй

-- Оровгод ⇒ сонсоогүй, би худлаа хэлээд хэрэггүй!

-- Хавангууд ⇒ сонсож байсан, хошуу ноёны тамгын газар ажиллаж байсан, нэг бол тэдний төрөл садангийн хүмүүс байх гэж бодож байна.

-- Хардал ⇒ сонсогдоогүй, ... баруун тийшээ тийм нэртэй хошуу байсан байх.

Батноров сумын Сэр-Одын Лувсаннамсрай гуайн (эр, 82 настай) ярьснаар : "Цэргийн албанд 19 настай, 1939 онд явахын өмнөхөн, цэргийн бүртгэл авч байхад анх «овог» гэж сонссон. Анх нагац ахаараа овоглож байсан. Нутагт тэр үед тэрний, тэдний хүүхэд, тэднийхэн гэж ярьдаг. Цэргийн бүртгэл авч байсан албаны хүмүүс : «яс угсаа» гэсэн асуултанд «ард халх гэж хариулж бай» гэж зааж өгсөн. Нутгийн хүмүүс «яс», «ураг» гэж ярьдаггүй, «хамаатан, садан» гэж ярьдаг байсан. Манай сумынханд :

-- аруд ⇒ байхгүй

-- баяд ⇒ мэдэхгүй, сонсогдоогүй

-- тангуд ⇒ сонсогдоогүй

-- тугчин ⇒ дуулсан, овгийн чанартай юм шиг байна. Сонин дээр гарсан нь таарч өгөхгүй бана.

-- харчу ⇒ дуулаагүй

-- шарнууд ⇒ залуу байхад дуулаагүй

-- боржигин ⇒ яригдаж байгаагүй, хожуу дуулсан

Норовлин сумын Зундуйн Жамбаа гуайн ярьснаар : "намайг 16-18 настай байхад «овог» гэж ярьдаггүй байсан. Эхлээд «овог» гэж эцгийн буюу эхийн нэр гэж ойлгогддог байв.

-- авгачуул ⇒ сонсоогүй

-- аруд ⇒ сонсогдоогүй

-- баатад ⇒ үгүй

-- батнай ⇒ манайд сонсогдоогүй

-- буряд гэж овог ⇒ сонсогдоогүй

-- галзууд ⇒ байхгүй, бурядад байдаг

-- гахан ⇒ дуулаагүй

-- гучид ⇒ байхгүй, бурядад байдаг

-- дэрт ⇒ сонсогдоогүй

-- жоргоон ⇒ үгүй

-- зургаад ⇒ үгүй

-- зэлмэ ⇒ мэдэхгүй

-- зэлмэн урианхан ⇒ сонсогдсон

-- махилаг ⇒ мэдэхгүй, сонсогдоогүй

- машаан ⇒ сонсогдоогүй
- нурун (нирун) ⇒ өөрийгээ тэгж хэлдэг хүн байхгүй
- оровгод ⇒ сонсоогүй
- сад ⇒ сонсогдоогүй
- тавд ⇒ сонсогдоогүй
- тугчин ⇒ энд байхгүй, Дорнот (Саруул гүний), Булган суманд туг тахьдаг хүмүүс бий
- урианхан ⇒ сонссон
- хавангууд ⇒ сонсоогүй
- халбин ⇒ байхгүй, буряд дотор бий
- харчу ⇒ сонсогдоогүй
- хорчид ⇒ сонсогдоогүй
- хурлагад ⇒ байхгүй
- цагаангууд ⇒ сонсогдоогүй
- чонод ⇒ сонсогдоогүй
- чээжнүүд ⇒ сонсогдоогүй
- шарнууд ⇒ үгүй
- эзээд ⇒ үгүй

Нийт мэдээлэгчдийн хэлснийг нэгтгэн үзвэл, бага насны үед нь «овог» гэж нэр томъёо ахуйн харьцаанд хэрэглэгддэггүй байжээ. Энэ нэр томъёогоор цэргийн бүртгэл авах, иргэний паспорт авах зэрэг албан хэрэгцээний үед засгийн төлөөлөгчид асууж, тайлбарлан бичиглэсэн байна. Тухайн үеийн хүмүүс «овог» гэж асуухад мэдэхгүй байсан нь тодорхой харагдаж байна. Үүнийг албаны хүмүүс, "орос хоёр овогтой байдаг, монгол хүн нэг овогтой" гэж хэлээд, "аавынхаа, ээжийнхээ, нэг бол өвөөгийнхөө нэрийг хэлж бай" гэж тайлбарлажээ. Судалгааны материалаас үзэхэд, «овог» хэмээх түүхийн ай ба орчин үеийн албан бичгийн нэр томъёо хоёрыг зааглан ойлгох, цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

Ном зүй

Билэгт, 1999 – Билэгт Л. Род и племя в устной истории монголов. Археологийн судлал. т.ХІХ, fasc.12. Улаанбаатар, 1999.

Билэгт, 2000 – Билэгт Л. Некоторые ономастические изыскания по данным «Сокровенного сказания» и «Сборника летописей». Археологийн судлал. т.ХХ. fasc. 11. Улаанбаатар, 2000.

Очир, Сэржээ, 1993, -- Очир А., Сэржээ Ж. Хэнтий аймгийнхны овгийн товч лавлах, угийн бичиг сэргээх зөвлөмж. Улаанбаатар, 1993.

Очир, Сэржээ, 1998 -- Очир А., Сэржээ Ж. Монголчуудын овгийн лавлах. Улаанбаатар, 1998.

Цэрэнханд, Билэгт, 2002 – Цэрэнханд Г., Билэгт Л., Монгол угсаатан бүрэлдэхэд Чингис хааны цэрэг—улс төрийн үйл ажиллагаа нөлөөлсөн нь // Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээ- ний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар, 2002.

Резюме

Г.Цэрэнханд
Л.Билэгт

**Предварительные результаты исследования
современного понятия термина «овог»**

В статье затрагиваются вопросы генезиса и трансформации современного этносоциального термина «овог» по данным полевого исследования 2002 года, в сомонах Баян-Овоо, Батноров, Норовлин, Хэнтэйского аймака. Предварительные результаты показывают несостоятельность отождествления «овог» с «фамилией или surname» функционирующих в европейских странах. Результаты исследования обобщены в выводах о том, что следует разграничить понятия исторической категории «овог» (племя) и современного термина «овог» употребляемых в официальных документах, и что требуется дальнейшее специальное исследование в этом направлении.

(ARC-ийн хүрээнд)